



Г МОНГОЛРОСЦВЕТМЕТ ТӨҮГ
ТӨРИЙН ӨМЧИТ ААТҮГ

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

1-105 дугаар байр, Бүяннэмэхийн өргөн чөлөө, Залус
хороолол, 7 дугаар баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг,
48090

Утас: 70593988 Факс: (976)70593988
Цахим шуудан: baigali@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.baigali.du.gov.mn


2023.04.26 № 85

танай _____ -ны № _____ -т

Г Санаал хүргүүлэх тухай Т

Тус аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт MV-004306 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй жоншны орд газрын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөлтэй танилцлаа.

Уг төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах хэсэгт ажилчдын бие засах газрыг хөрсөнд нэвчихгүй, байгальд ээлтэй байдлаар шийдвэрлэх, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр зэрлэг амьтдыг ундаалах хөв цөөрөм байгуулах, хог хаягдлын менежментийн хүрээнд ангилан ялгасан энгийн хог хаягдлаа дахивар авах цэгт нийлүүлэх ажлуудыг нэмж батлуулахыг анхаарна уу.



Дундговь аймгийн Байгаль орчин, аялал
жуулчлалын газар
Газар
Дарга
Ням-Очир Гантулга
2023-04-26 15:25:16

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1 Төслийн нэр	3
1.2 Төслийн зорилго:	3
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
1.5 Төслийн хүчин чадал болон ашиглалтын хугацаа	5
1.6 Уурхайн тоног төхөөрөмж	5
1.6 Төслийн ажиллах горим.....	6
1.8 Төслийн дэд бүтэц.....	7
1.8.1 Уурхайн барилга байгууламж.....	7
1.8.2 Цахилгаан хангамж:	7
1.8.3 Усан хангамж	7
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл.....	8
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	10
3.1 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим.....	12
БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
4.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт	16
4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө	17
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	18
БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
6.1 Техникийн нөхөн сэргээлт.....	23
БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	28
БҮЛЭГ 13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ	31
БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл	3
Хүснэгт 2 Төслийн талбайн солбилцол.....	3
Хүснэгт 3 Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	5
Хүснэгт 4 Ил уурхайн ажлын горим	6
Хүснэгт 5 Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим	12
Хүснэгт 6 Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шинж чанараар ангилсан байдал	13
Хүснэгт 7 БОМТ-ний задаргаа	17
Хүснэгт 8 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	18
Хүснэгт 9 Техникийн нөхөн сэргээлт	23
Хүснэгт 10 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25
Хүснэгт 11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	26
Хүснэгт 12 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр..	28
Хүснэгт 13 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга.....	31

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 14 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах,
хэлэлцүүлэх хуваарь..... 32

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Төслийн талбайн байршил	4
Зураг 2 Уурхайн тоног төхөөрөмж	6
Зураг 3 Төслийн талбайн зураг.....	7
Зураг 4 Хөрсний сүлжээний зураг.....	8
Зураг 5 Ургамлын сүлжээний зураг	9
Зураг 6 Төслийн нөлөөллийн эрчмийн зураг	10

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

“Хөх дэл” жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

1.2 Төслийн зорилго:

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт орших MV-004487 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд “Монголросцвет” ТӨҮГ нь олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаа явуулах бөгөөд “Хөх дэл” жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглан жонш олборлож сумынхаа төдийгүй монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах зорилготой.

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

“Монголросцветмет” ТӨҮГ нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Хөх дэл” жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн БОННҮ-ний тайланг 2019 оны БОАЖЯНЫ хурлаар хэлэлцэн батлуулсан бөгөөд тус уурхай нь одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Монголросцветмет” ТӨҮГ
Улсын бүртгэлийн дугаар	9019029071
Регистрийн дугаар	2550466
Тусгай зөвшөөрөлийн дугаар	MV-004487
Хаяг	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22-р хороо өөрийн байр
Утас	11458590

1.4 Төслийн байршил


Хөх дэлийн жоншны орд газарт Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших 4487А тусгай зөвшөөрөлтэй Зүүн үнэгтийн 92.5 га, 4360А тусгай зөвшөөрөлтэй Төв үнэгтийн 92.49 га талбай, нийтдээ 184.99 га талбай хамрагдана. Уг талбай нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт тус сумын төвөөс урагш 35 км, аймгийн төв Мандалговиос 150 км, Бор-Өндөр УБҮ-ийн төмөр замаас 170 км зайд оршдог.

- Засаг захиргаа: Дундговь аймаг, Баянжаргалан сум
- Талбайн нэр: “Хөх дэл”
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Жонш
- Трапецийн номенклатур: L-48-23
- Талбайн нийт хэмжээ: 92 га.
- MV-004487 тоот тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол

Хүснэгт 2 Төслийн талбайн солбилцол

№	Уртраг	Өргөрөг
1	107° 57' 26.5"	45° 30' 43.62"
2	107° 57' 26.5"	45° 31' 3.62"
3	107° 56' 17.51"	45° 31' 3.62"
4	107° 56' 17.51"	45° 30' 43.62"

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 1 Төслийн талбайн байршил

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.5 Төслийн хүчин чадал болон ашиглалтын хугацаа

Уурхай нь жилд 35.0 мян.тн-ын хүчин чадалтайгаар 3 жил ашиглана. Уурхайн ашиглалтын хугацаанд нийт 652.5 мян.м³ хөрс хуулж, 93 мян.тн хүдэр олборлоно. Ил уурхайн хөрс хуулалт, хүдэр олборлолтын хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3 Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Ашиглалтын жилүүд	Хүдрийн нөөц		Дундаж агуулга	Металлын нөөц	Хөрс хуулалтын хэмжээ	Хөрс хуулалтын коэффициент
	м³	тн	%	тн	м³	м³/тн
1-р жил	9,172.1	23,847.4	29.1	6,939.6	169,653.6	7.1
2-р жил	13,461.5	35,000.0	30.2	10,570.0	228,379.9	6.5
3-р жил	13,461.5	35,000.0	28.0	9,803.0	254,480.5	7.3
Нийт	36,095.1	93,847.4	29.1	27,312.6	652,514.0	7.0




График 1 Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

1.6 Уурхайн тоног төхөөрөмж

Дотоод тээвэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн 25 тн-ийн даацтай HOWO загварын автосамосвал ашиглахаар төлөвлөсөн. Бас дээр нь уурхайн овоолгын ажилд SD23 маркийн бульдозер ашиглана.

Бутлан ангилах хэсгийн тоног төхөөрөмжийн сонголтыг хийхдээ дараах үндсэн зарчмуудыг баримталсан. Үүнд:

- Технологийн тооцооллын үр дүн
 - Тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, засвар үйлчилгээний хялбар нөхцөлийг хангасан

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Тоног төхөөрөмжийн эдэлгээ удаан, сэлбэг хэрэгслийн олдоц сайн



Зураг 2 Уурхайн тоног төхөөрөмж

1.6 Төслийн ажиллах горим

Уулын ажил нь жилд 8 сар явагдана. Үйлдвэрлэлийн үндсэн процессууд нь тасралтгүй 7 хоног, өдөрт 2 ээлжээр 10 цагаар, жилд 220 хоног ажиллана.

Хүснэгт 4 Ил уурхайн ажлын горим

Үзүүлэлт	Х.нэгж	Хоног
Календарь хоног	хоног	240
Жилд ажиллах сар	сар	8
Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
Ээлжийн тоо	ээлж	2
Ээлжинд ажиллах цаг	цаг	12
Баяр ёслолын хоног	хоног	10
Цаг агаарын saatol	хоног	8
Бэлтгэл ажлын хоног	хоног	2
Жилд ажиллах хугацаа	хоног	220

1.7 Уурхайн ашиглалтын систем

“Хөх дэл” жоншны ордын хөрсний зузаан нь дунджаар 30 м байна. Иймд шимт хөрсийг 0.2 м зузаантайгаар хуулан овоолно.

Ордын жонш нь хэвтээ ойролцоогоор 1^0 уналтай, нөөцийн блокуудын өргөн жигд үргэлжилдэг тул ашиглалт явуулсан талбайд гадаад овоолго хийж ашигладаг ба ордын ашиглалтад ил аргаар авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системийг ашиглаж байна.

1.8 Төслийн дэд бүтэц

1.8.1 Уурхайн барилга байгууламж

Уурхай, үйлдвэрийн барилга байгууламжид захиргааны байр, ажилчдын болон хоолны байр, агуулах-засварын байр багтах бөгөөд эдгээр нь уурхайн зүүн талд байрлана.



Зураг 3 Төслийн талбайн зураг

Төслийн талбайд ажилчдын амрах байр болон гал тогоог шийдвэрлэхийн тулд 10 ширхэг гэр байрлуулсан байна. Шатахуун түгээх станцын агуулахыг 60 тонны ёмкость байрлуулсан байна.

1.8.2 Цахилгаан хангамж:

Уурхайн нийт цахилгааны хэрэглээг 50 кВт болон 160 кВт-ийн чадалтай дизель үүсгэврээр хангахаар төлөвлөсөн. Уурхайд бутлан ялгах хэсэг, ил уурхайн гэрэлтүүлэг, хотхоны гэсэн цахилгаан хэрэглэгч байна.

1.8.3 Усан хангамж

Үйлдвэрлэлийн технологид ус ашиглахгүй бөгөөд зөвхөн ажилчдын унд ахуй, авто замын тоосжилт дарах, болон нөхөн сэргээлтэд ус ашиглана. Унд ахуйн болон тоосжилт дарах нөхөн сэргээлтийн усыг өөрийн эзэмшлийн худгаас зөөврөөр хангана.

Усны эх үүсвэр:

- Өрөмдмөл гүний худаг
- Усны ундарга 15 л/сек

Уурхайн ашиглалтын хүрээнд дараах усны хэрэглэгч байна. Үнд:

- Ажилчдын унд ахуйн хэрэглээ
- Уурхайн зам талбайн тоосжилт

- Нөхөн сэргээлт


БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл

Далайн түвшнээс дээш 1100-1465 метр өргөгдсөн. Хайргархаг шавранцар цайвар хүрэн, хужир шаварлаг элсэнцэр буюу хөнгөн шавранцар бор хөрс голлосон уул толгодлог гадаргатай. Аль ч улиралд таван хошуу мал идээшин дасах тал хээр хосолсон нутаг.

Уул зүй: Бага хэрчигдэлтэй намхан уулс, толгод, гувээрхэг гадаргуу бүхий тачир ургамлын бүрхэвчтэй ой мод, гол горхигүй, хуурай эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд оршдог. Уул толгод нь тэгшивтэр бөмбөгөр оройтой, налуу хажуутай, гуу жалгандаа үерийн усаар идэгдсэн, эгц өргөрхэг гуу, хуурай сайруудтай, толгод хоорондын битүү хотгоруудад хур бороотой үед түр зуурын жижиг нуур цөөрөм үүсдэг.

Хөрс: Нутгийн хойд ба төв хэсгээр хээрийн хар хүрэн, цайвар хүрэн хөрс, өмнөд хэсгээр нь.govийн саарал хөрс тархжээ.




Зураг 4 Хөрсний сүлжээний зураг

Ус зүйн сүлжээ: Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 50 м³ хоног хүчин чадалтай 5 худагтай, ус зөөлрүүлэх, цэнгэгшүүлэх 2 төхөөрөмж байгаа боловч төхөөрөмж ашиглалтаас гарсан, засварлах боломжгүй тул гүний худгаас усыг шууд насocoор татаж хоолойгоор түгээж байна. Төвлөрсөн усан хангамжаар нэг байгууллага холбогдсон бусад аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүд ус түгээх байрнаас усаа авч байна.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөх дэл жоншны орд нь Умард голын гүвээт халхын дундад голын ай савд хамаарч байна.

Ургамал: Нутгийн хойд ба дунд хэсгээр хээрийн өвслөг ургамал, урд хэсгээр нь.govийн ургамал ургана. Төсөл хэрэгжих талбайд агь, гашуу, ерхөг, хазаар, дэрс, таана, хөмүүл, хялгана голлон ургана. Чихэр өвс, царван, таван салаа, бажууна зэрэг эмийн ургамал, буйлс, хайлс, яргай, бургас, харгана зэрэг модлог ургамал ургана.




Зураг 5 Ургамлын сүлжээний зураг

Ан амьтан: Хар сүүлт, цагаан зээр, тарвага зэрэг ан амьтан амьдардаг. Нутгийн уулархаг газраар нь ирвэс, шилүүс, чоно, аргал, янгир нүүдэллэн амьдардаг байна.

Цаг агаарын хувьд: Агаарын дундаж температур өвөл 1-2 сард 30 хэм хүрч хүйтэредэг. 7 сарын сүүлч 8 сар хүртэл зундаа 35 хэм хүрч халдаг эрс тэrs уур амьсгалтай.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Монголросцветмет” ТӨҮГ-ны Дундговь аймгийн Баянжаргалан нутагт орших “Хөхдэл” төв бүс”-ийн хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаа хэрэгжсэнээр тухайн уурхайн бүс тодорхой хэмжээгээр элэгдэлд орно. Элэгдэл эвдрэлд оруулах гол хүчин зүйл нь хүнд даацын машины хөдөлгөөн, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үеийн тоос тоосонцор, дуу чимээ зэрэг юм.



Зураг 6 Төслийн нөлөөллийн эрчмийн зураг

Мөн төсөл хэрэгжсэнээр байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Төслийн үйл ажиллагаанаас хамааран хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийг тооцоолон ArcGIS 10.5 программд зураглахад 300 метрийн радиуст нөлөөллийн эрчим их буюу хүчтэй, 500 метр радиуст нөлөөллийн эрчим дунд буюу саармаг, 800 метрийн радиуст нөлөөллийн эрчим бага буюу сул байна

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ. Уурхайн овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо, уурхайд ажиллах машин техникийн шингэн түлшний шаталтаас ялгарах утсаа, хөө тортог, хорт хийнүүд, ажилчдын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол, өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо, хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

дүү чимээ болон хорт хий утас гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө.

Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл: Төслийн зүгээс газрын гадарга болон хэвлийд үзүүлэх гол нөлөөлөл нь барилга угсралтын ажил болон төслийн үйл ажиллагаатай холбоотой уурхайн карьер, овоолго болон тээврийн хөдөлгөөн зэрэг эх үүсвэрүүдээс үүснэ.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл : Төслийн хүрээнд төлөвлөж буй ил уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн үйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мөн химиин бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химиийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг.

Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл: Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дараход цэвэр усны нөөц хомсдох, Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох, Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах, Баяжуулах үйл ажиллагаа явуулахад химиийн бодис алдагдахаас үүдэн хөрсний болон гүний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулахаас үүдэн хөрсний усыг бохирдуулах, Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч халихаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг бохирдуулах эрсдэлтэй байна.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Төслийн талбайд дэд бүтэц байгуулах, шимт хөрсний болон хаягдал чулуулгийн овоолго бий болгох, уурхайн зам, дэд бүтцүүдийн барилгын ажил хийгдэх зэрэгтэй холбоотойгоор хөрс хуулалт явагдах ба эдгээр үйл ажиллагаа нь ургамлан нөмрөгт шууд болон шууд бус нөлөөллийг үзүүлнэ. Мөн уурхайн байнгын үйл ажиллагаа ургамлан нөмрөгт дам нөлөөлөл богино ба урт хугацаанд үзүүлсээр байх юм.

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл: Барилга угсралтын үед ажиллах хүнд даацын автомашин, техник хэрэгслүүдийн дуу чимээнээс амьтад үргэн дайжих, Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох, Тоосжилтын улмаас ургамал ургах чадвараа алдан ургамлын арви багассанаас өвсөн тэжээлтнүүд хоол тэжээлийн хомсдолд

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

орох, Төслийн ажилчид санаандгүй болон санаатайгаар амьтдыг устгаж болзошгүй, Шувууд утаанд хордох, цахилгаан хүчдэлд цохиулах зэрэг багтана.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Төслийг хэрэгжүүлэхэд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах нь оршин суугчдын амьжиргаа, нийгэм эдийн засгийн хөгжилд зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

3.1 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

“Монголросцветмет” ТӨҮГ-ЫН “Хөх дэл” нэртэй жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоох зорилгоор төсөл хэрэгжих орчны ерөнхий байдалтай газар дээр нь танилцаж, шаардлагатай газруудаас сорыц авч, шинжилгээ хийлгэсний үндсэн дээр боловсруулалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Аливаа төслийн үйл ажиллагаанаас тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг болон хүн амын амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх, тэдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тогтооход магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ арга нь экспертуудийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруулах замаар хэрэгждэг. Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байна, байхгүй гэсэн зарчмаар үнэлэх бөгөөд нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэнэ. Ингэхдээ уг үнэлгээнд оролцсон шинжээч, судлаачдын дүгнэлтийг үндэслэн 2 төрлийн жагсаалт гаргасан. Нөлөөллийн хэлбэр нь үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь “шууд”, “шууд бус”, “буцаж нөлөөлөх”, “буцалтгүй нөлөөлөх”, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд “богино хугацааны”, “урт хугацааны”, эрчмийн хувьд “бага зэрэг”, “дунд”, “хүчтэй” гэхчлэн ангилсан магадлах жагсаах аргаар тодорхойлсон. Доорх хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5 Төслийн болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл		Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зураг нөлөөлөх
Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл										
1	Газрын доорх усны чанар	x		x			x	x		
2	Газрын доорх усны нөөц	x			x		x	x		
3	Хөрсний элэгдэл, эвдрэл	x			x	x		x		
4	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x							
Байгаль орчны чанарын өөрчлөлт										

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

5	Усны чанар, хэмжээ	x	x	x	x	x	x	x	x			
6	Агаарын бохирдол	x	x			x	x					
7	Хөрсний бохирдол	x		x	x		x					
8	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл	x	x			x		x				
9	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x					x					
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл												
10	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+			+		+		+			
11	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх											
12	Хүн, амын орлого нэмэгдэх	+			+		+		+			
13	Хүн амын тоо өөрчлөгдөх											
Эдийн засаг, байгаль орчин												
14	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+		+	+		+		+			
15	Орон нутгийн орлого нэмэгдэх	+			+		+		+			
16	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+		+		+	+				
17	Ажлын байр нэмэгдэх	+			+	+			+			
18	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+	+		+				
19	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x	x	x			x				
Бусад нөлөөлөл												
20	Хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих		x	x	x		x					
21	Нөлөөллийн тоо ширхэг	Sөрөг	2	9	6	3	5	4	7	3		
		Эерэг	6	1	1	1	6	2	5	2	4	1

Тайлбар: “+” эерэг, “x” сөрөг

Хүснэгт 6 Нөлөөллийн эрчим, цар хүрээ, шинж чанараар ангилсан байдал

Шууд нөлөөллийн тоо: 8

Эерэг нөлөөлөл нь: 6	Сөрөг нөлөөлөл нь: 2
<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ажлын байр нэмэгдэх - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх 	<ul style="list-style-type: none"> - Хөрсний элэгдэл, эвдрэл - Дуу чимээ, шуугианы нөлөө

Шууд бус нөлөөллийн тоо: 10

Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь: 9
<ul style="list-style-type: none"> - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох 	<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Усны чанар, хэмжээ - Агаарын бохирдол - Хөрсний бохирдол - Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	<ul style="list-style-type: none"> - Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх - Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих
Төрөө зохицуулагдах нөлөөллийн тоо: 1	
Эерэг нөлөөлөл нь: 1	Сөрөг нөлөөлөл нь:
<ul style="list-style-type: none"> - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх 	
Богино хугацааны нөлөөллийн тоо: 7	
Сөрөг нөлөөлөл нь: 6	Эерэг нөлөөлөл нь: 1
<ul style="list-style-type: none"> - Усны чанар, хэмжээ - Агаарын бохирдол - Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл - Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх - Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих 	<ul style="list-style-type: none"> - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Урт хугацааны нөлөөллийн тоо : 9	
Сөрөг нөлөөлөл нь: 3	Эерэг нөлөөлөл нь: 6
<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Хөрсний элэгдэл, эвдрэл - Хөрсний бохирдол 	<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох - Ажлын байр нэмэгдэх
Буцах нөлөөллийн тоо: 7	
Сөрөг нөлөөлөл нь: 5	Эерэг нөлөөлөл нь: 2
<ul style="list-style-type: none"> - Хөрсний элэгдэл, эвдрэл - Усны чанар, хэмжээ - Хөрсний бохирдол - Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх - Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих 	<ul style="list-style-type: none"> - Ажлын байр нэмэгдэх - Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Буцалтгүй нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 4	Эерэг нөлөөлөл нь: 5
<ul style="list-style-type: none"> - Газрын доорх усны чанар - Газрын доорх усны нөөц - Агаарын бохирдол - Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл 	<ul style="list-style-type: none"> - Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх - Хүн, амын орлого нэмэгдэх - Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх - Орон нутгийн орлого нэмэгдэх - Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох
Сулавтар нөлөөллийн тоо: 9	
Сөрөг нөлөөлөл нь: 7	Эерэг нөлөөлөл нь: 2

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

<ul style="list-style-type: none"> — Газрын доорх усны чанар — Газрын доорх усны нөөц — Агаарын бохирдол — Хөрсний бохирдол — Дуу чимээ, шуугианы нөлөөлөл — Ахуйн хог хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржил 	<ul style="list-style-type: none"> — Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох — Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх
Дунд зэргийн нөлөөллийн тоо: 7	
Сөрөг нөлөөлөл нь: 3	Эерэг нөлөөлөл нь: 4
<ul style="list-style-type: none"> — Усны чанар, хэмжээ — Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл — Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх 	<ul style="list-style-type: none"> — Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх — Хүн, амын орлого нэмэгдэх — Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх — Ажлын байр нэмэгдэх
Эрчимтэй нөлөөллийн тоо : 1	
Сөрөг нөлөөлөл нь: 0	Эерэг нөлөөлөл нь: 1
	<ul style="list-style-type: none"> — Орон нутгийн орлого нэмэгдэх

БҮЛЭГ 4. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 Менежментийн төлөвлөгөөний гол зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын “Хөх дэл” нэртэй жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино. Энэ хүрээнд:

1. Тус төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө зэргийг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө;
2. Мөн тус төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус тус боловсруулсан болно.
3. Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо.

Тус төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах,

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

тайлагнах журам, мөн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримтлан боловсруулсан бөгөөд төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд багтах дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно. Харин нөхөн сэргээлтийн төлөвлөгөө болон эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тус тус оруулсан болно.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2023 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **4.580.0 мян.төг** зарцуулахаар төсөвлөв. Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг 12 сарын 30-ны дотор холбогдох байгууллагад хүргүүлж байх зайлшгүй шаардлагатай болно.

Хүснэгт 7 БОМТ-ний задаргаа

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	1000.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	500.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	500.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	700.0
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	500.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	680.0
9	Удирдлага зохион байгуулалтын талаар авах арга хэмжээ	500.0
10	БОМТ-ыг оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	200.0
	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	4.580.0

4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө

“Монголросцветмет” ТӨҮГ-ЫН “Хөх дэл” нэртэй жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг нэгтгэж доорх хүснэгтэд тусгалаа.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжи х нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
1		Агаарын чанар							
Уурхайн тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын эх үүсвэрүүд: -Уурхайн олборлолтын үеийн хөрс хуулалт, олборлолт, овоолго хийх газар шорооны ажил, -Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох -Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт	Уурхайн олборлолтын үе шатандтоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	Агаарын тухай хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688:2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004 Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003	
		Үйл ажиллагааны турш	-		-	ОХШХ-т тусгасан	+		
	Уурхайд орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайл тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+		
	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+		

Ажиллагсад болон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх	төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах							
	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хушуувч, амны маск, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээ р ажилчдыг хангах сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	-		-	Осол эрсдэлийн менежментийн зардлаар	+	
Хөрсөн бүрхэвч								
Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хог хаядал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх. Шатах тослох материал, барилгын материалын хог хаядал, шатахуун	Шимт хөрсний овоолго хийх хадгалах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	“Газрын тухай” хууль MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
	Уурхайн орчны замыг стандартын дагуу тавих, тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	6	
	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.А-ны зардлаар	+	

	асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.а-ны зардлаар	+	
		Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгтэй хураах	Үйл ажиллагааны турш	-		-	Ү.а-ны зардлаар	+	
	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх, сул шороо бүхий газруудаас тоос босох	Төслийн талбай дахь сул шороо бүхий газруудыг ургамалжуулах, мод бут тарих	Төслийн талбайд	-		-	Нөхөн сэргээх арга хэмжээнд тусгав	+	MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS
3 Усны нөөц, усны чанарт									
	Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сүргөөр нөлөөлж болзошгүй.	Ахуйн бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах,	Төсөл хэрэгжих талбайд	-		-	Ү.а-ны зардлаар	+	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Усны тухай хууль MNS 4288:1995 /ЗГ-ын 2013 оны 326 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласны
		Ахуйн усны хэрэглээг тооцох хэмнэлттэй зарцуулах техник технологи ашиглах	Төсөл хэрэгжих талбайд	-		-	300.0	+	

		Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	Төслийн явцад	-		-	Ү.а-ны зардлаар	+	төлбөрийн хэмжээ/ хувь
		Ахуйн гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл худалдаж авах (галын хор, гал унтраагч, ус цацагч гэх мэт)	Галын аюулгүй ажиллагааны хүрээнд	-		-	Осол эрсдэлийн менежментийн зардалд	+	
		Ажилчдын гал тогоо, амрах байр, хог хаягдлын цэг, 00-ийн ариутгал халдвартгүйжүүлэлт	Ажилчдын байрны хүрээнд	-		-	Орчны хяналт шинжилгээний зардалд	Сард 1 удаа	
4	Амьтны аймаг, ургамлан нэмрөг								
	Хөрс ургамлан нэмрөг доройтох	Бүх барилгуудыг явган хүний замаар холбож нийтийн үйлчилгээний зам талбайг сайжруулж хучиж, орчны хөрс ургамлыг хамгаалах	Уурхайн хүрээнд	-		-	Ү.а-ны зардлаар	+	Хог хаягдлын тухай хууль, 2017 он Хаягдлын цэгийн стандарт MNS 5906:2015
	Авто машины зогсоол, засварын цех	Авто зогсоол, гаднах талбайд анхааруулах самбар болон таних тэмдэг байршуулах,	Авто зогсоолын хүрээнд	-		-	Ү.а-ны зардлаар	+	

	Хог хаягдлыг амьтанд хоргүйгээр шийдвэрлэх	Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Уурхайн хог хаягдлын хүрээнд	-		-	Хог хаягдлын мененжментийн зардалд	+	Хог хаягдлын тухай хууль 2017 он
5	Дуу чимээ								
	Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх	Дуу шуугианы хэмжилт (2 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмийн ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах	Уурхайн үйл ажиллагааны явцад	-.	-	Орчны хяналт шинжилгээний зардалд	Улиралд нэг удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилтийг хийнэ	MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм-хэмжээ түвшний
	Нийт			1000.0 сая.төг					

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 Техникийн нөхөн сэргээлт

Хүснэгт 9 Техникийн нөхөн сэргээлт

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа (он), давтамж	Баримтлах эрхзүйнбаримт бичиг, стандарт аргачлал	
							2023		
1					ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ				
	Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа болон ашиглалтын явцад уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилгоор нөхөн сэргээхэд техникийн нөхөн сэргээлтийн гол зорилт юм.	Тухайн карьераас гаргасан уулын цулыг буцаан булж тэгшилнэ.	Үйл ажиллагаа ны дуусмагц	2.5 га талбайд	Уулын ажлын төлөвлөгөөний зардлаар	Уулын ажлын төлөвлөгөөний зардлаар	2023 он	“Байгаль орчныг хамгаалах тухай”	
2					БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ				
	0.2м зузаан үржил шимт хөрсөөр хучихаар төлөвлөсөн	0.2м зузаан үржил шимт хөрсөөр хучихаар төлөвлөсөн	Үйл ажиллагаа ны дуусмагц	2.5 га талбайд	-	-	2023	“Байгаль орчныг хамгаалах тухай”	
		Олон наст ургамал суулгана	Үйл ажиллагаа ны дуусмагц	2.5 га талбайд	-	-	2023	“Байгаль орчныг хамгаалах тухай”	
	Нийт дүн мян.төг				500.0				

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗЫН БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №. 1 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйнбаримт бичиг, стандарт аргачлал
					2023		
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ							
1	Зохион байгуулалтгүй аялал жуулчлал, зүй бус ашиглалтаас Байгалийн үзэсгэлэнт газруудын орчин хог хаягдлаар бохирдож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа зам гарч, байгалийн унаган төрх алдагдаж байна.	Олон наст ургамал тарихаар төлөвлөсөн		Үйл ажиллагааны эхэнд	2023 он	ҮА-ний зардалд (ДХ ажлын зардал)	MNS 5914:2015, MNS 4597:2013
2	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд	Орон нутгаас санал болгосон газарт 500 ширхэг мод тарихаар төлөвлөсөн		Үйл ажиллагааны эхэнд	2023 он	ҮА-ний зардалд (ДХ ажлын зардал)	
Нийт дүн, мян.төг		500.0					

БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

БҮЛЭГ 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

БҮЛЭГ 10.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан осол гарах	Цаг агаарын мэдээг байнга авч үйл ажиллагаатайгаа холбон ажиллах, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх гарын авлагатай болох	Төсөл хэрэгжүүлэгчийн удирдах ажилтан албан хаагчдад үүрэг даалгавар өгөх	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан			Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	
	Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	Төслийн бүхий л үед хэрэгжүүлэх ХХАА-ны гарын авлагатай болох	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		Байнга		
	Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох	Ус, элс, шороо, хүрэцэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт	2	200.0	100.0	7 сард		
	Болзошгүй аюул ослын үед ашиглах мөнгөн хуримтлал бүрдүүлэх		-	Үйл зардлаар ажиллагааны		Байнга		
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний тэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших		-					
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах		12					
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөө батлуулна.		-			6 сард		
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах		-			III улиралд		
Эрүүл мэнд	Ажилчдыг жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах		1	-		Жилд 1 удаа		
Нийт зардал (мян.төг)				700.000				

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
							2023 он	
Хог хаягдлын цэгийг MNS 5906:2015 стандартад нийцүүлэн ашиглалтад оруулах	Хатуу хог хаягдлын түр цэгийн хөрсийг бетондож, битүүмжлэл сайтай 3 тасалгаатай хатуу хаягдлын цэгийн стандартын шаардлагад нийцүүлэн хөрснөөс тусгаарласан битүүмжлэл сайтай галд тэсвэртэй материалыар доторлох	Хог хаягдлын цэгт				200.00	2 улиралд	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011
Ахуйн хатуу хог хаягдаар газрын гадарга бохирдох;	Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдлын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлцуулах.	Төслийн талбайн бүх барилга байгууламж уудад				250.00	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль
Хог хаягдал, ШТМ-ын хаягдал хурын усаар дамжин гүний усыг бохирдуулах	Үнд ахуйн усыг лабораторын шинжилгээнд тогтсон хуваарийн дагуу шинжлүүлж байх	Төслийн талбай дахь худгийн усанд				ОХШХ-т тусгасан аар	IV улиралд	MNS 3936:1986 Үндны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх MNS 0900:2005 Үндны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх харьяа нийтийн үйлчилгээний албатай хог хаягдлын гэрээ хийх	Ахуйн хатуу, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, ажилчдын бие засах газар болон бохир ус хуримтлуулах цэгийг холбогдох хууль, стандартын шаардлагад нийцүүлэн хүрээлэн буй орчныг бохирдуулахгүй байхаар төлөвлөн	Ахуйн хаягдлын хүрээнд				-	Сар бүр	Усны тухай хууль, 2012 он Гүний усыг бохирдоос хамгаалах ерөнхий

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

шинээр байгуулах, үүссэн шингэн хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах								шаардлагууд. MNS 3342:1982
Нийт	500.000 мян.төг							

БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 12 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж 2023 он	Давта мжийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд	
Агаарын чанар									
1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	1. Төслийн үйл ажиллагааны үед агаарын чанарын дээжлэлт хийх 2. Төслийн үйл ажиллагааны үед ашиглах тээврийн хэрэгслийг жил бүр үзлэгт хамруулж, агаарын бохирдлын төлбөрийг төлөх, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх.	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд	Улирал тутамд	Жилд 1 удаа	40.0	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 40.0 х жилд 2 удаа* 1 жил НИЙТ 80.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаа р хийлгэх	Уурхайн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	Хүдрийг буулгах овоолох цэгт	Улирал тутамд	Жилд 1 удаа	40.0	Шинжилгээний зардал: 1 удаагийнх 40.0 x 1 цэг х жилд 2 удаа*1 жил НИЙТ 80.0	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	Хүнд даацын машины тээврийн зам, уурхайн ойр орчимд 2 цэгт	Улирал тутамд	Жилд 1 удаа	30.0	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 30.0 х жилд 2 удаа* 1 жил НИЙТ 60.0		

Хөрсний бохирдол								
1	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устэрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үргжил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 2 цэг сонгох	Хагас жил тутамд	Жилд 1 удаа	20.0	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1жил /40.0/ НИЙТ 80,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж-20.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдаар хөрс бохирдох	Дээрх 2 цэгт	2023 он	Жилд 1 удаа	20	2 цэгт х 2 дээж х жилд 2 удаа х 1 жил х 20.0 Нийт 80,0 хүнд металлын шинжилгээ 1 дээж-15.0 төг/	
Усны хяналт шинжилгээ								
2	Усны чанар pH, уссан нийт давс (жингийн	Төслийн талбай орчим	Үнд ахуйн усыг хангаж буй уснаас	2023 он	Жилд 1 удаа	50.0		MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХӨХ ДЭЛ” НЭРТЭЙ ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ УУРХАЙН АРГААР
АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ 2023 ОНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

	аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ					50.0*2 удаа х 1жил НИЙТ 100.0	MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Үндны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3	Усны түвшин усны ундарга нөөц	Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх	Төвийн шугамын ус	2023 он			
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2023 ОНЫ ЗАРДЛЫН ДҮН							680.000

БҮЛЭГ 13. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Хүснэгт 13 БОМТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Хугацаа 2023 он
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандaa хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Уурхайн хүрээнд	Дотоод зохион байгуулалтаар		2023 он
2	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар жилд 1 удаа сургалт, судалгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Уурхайн хүрээнд	Осол эрсдэлийн менежментийн зардалд		2023 он
3	Байгаль хамгаалахад сум багийн холбогдох ажилтнуудын оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	Үйл ажиллагааны хүрээнд	Удирдлагын түвшинд		2023 он
4	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Уурхайн хүрээнд	Дотоод төлөвлөлтөөр		2023 он
5	Бүх ажиллагсдыг жилд 1 удаа нарийн мэргэжлийн эмч нарт хамруулж байх	Уурхайн хүрээнд	-	2023 он	2023 он
6	ХАБЭА дүрмийн дагуу үзлэг, шалгалтыг тогтмолжуулж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгах ажлыг зохион байгуулах	Уурхайн хүрээнд	Дотоод зохион байгуулалтаар		Улирал бүр
7	Ажилчдыг шаардлагатай хувцас, тусгай хамгаалах, амны хаалт, малгай зэргээр хангах	Уурхайн хүрээнд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүр
8	Яаралтай анхны тусlamжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Уурхайн хүрээнд	50.0	100.0	Жилд 2 удаа
10	Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийлгэх				5 жилд 1 удаа
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал					500.0

**БҮЛЭГ 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД
ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

Хүснэгт 14 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжих бүй Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутгийн оршин суугч болон засаг захиргааны байгууллагад танилцуулж хэлэлцүүлнэ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	2023 оны IV улиралд	200,0	БО-ны мэргэжилтэн, уурхайн дарга	Сумын иргэдийн нийтийн хурлын танхим, төсөл хэрэгжүүлж тайлан гаргах
Дундговь аймгийн БОАЖГазарт биелэлтийн тайлан, дараа оны БОМТ-г хянуулах	Хянуулах	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	2023.11.01-нд хүргүүлэх	-	“Монголросцветмет” ТӨҮГ	Дундговь аймгийн БОАЖГазарт биелэлтийн тайлан, дараа оны БОМТ-г хянуулах
Нийт				200.0		